

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн Жаргалант сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ОРА-2026/001/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Эрдэнэт хот  
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва  
Утас: 70353088 Цахим хаяг: purevlkhagvar@audit.gov.mn  
Аудитын менежер: Б.Буян-Ундрах  
Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn  
Аудитор: А.Лхагвагэрэл  
Утас: 70350757 Цахим хаяг: lkhagvagerela@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## НЭГ. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### **ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, Эрх чөлөөний өргөн чөлөө-3,  
Уртбулаг баг, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61033  
Утас: (976) 7035 9626  
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2026.03.25 № 96  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ОРХОН АЙМГИЙН ЖАРГАЛАНТ  
СУМЫН ЗАСАГ ДАРГА Л.УЧРАЛ  
ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Орхон аймгийн Жаргалант сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Жаргалант сумын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### **Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### **Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд 24,745.1 сая төгрөгийн төсөв батлагдсаныг 5,536.9 сая төгрөгөөр бууруулж, 19,208.2 сая төгрөгөөр тодотгон баталж, гүйцэтгэлээр 13,246.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын зардлын тусгай дансгүй тул холбогдох зарцуулалтыг Жаргалант сумын Засаг даргын тамгын газрын үйл ажиллагааны үндсэн дансаар дамжуулж байна.

Орон нутгийн төсөвт төвлөрүүлэх 8 нэр төрлийн орлогын төлөвлөгөө тасарсан ч нийт орлогын төлөвлөгөө 6.9 хувиар давж биелжээ.

#### **Аудитын гол асуудал**

Тайлант онд боловсролын салбарт 410.0 сая төгрөг, эрүүл мэндийн салбарт 53.5 сая төгрөг, соёлын салбарт 110.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийгдсэн байна.

2024 онд эхэлсэн Орон нутгийн хөгжлийн сангийн 1,300.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалттай “Улаантолгой багт цэцэрлэгт хүрээлэн байгуулах” ажил тайлант онд хэрэгжиж дууссан байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Орхон аймгийн Засаг даргатай байгуулсан 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 90.8 хувьтай биелүүлж ажилласан байна.

Жаргалант сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2025 оны хэрэгжилтийн биелэлтийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 85.1 хувь буюу “Үр дүнтэй” гэж үнэлсэн байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй аудитор аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

  
  
П.ПҮРЭВЛХАГВА

**ХОЁР. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	/мянган төгрөгөөр/	
		2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		4,711,545.73	9,357,669.13
1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	3,556,390.8	7,465,462.42
1.1.3 АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	262,871.23	309,264.29
1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	805,583.7	1,428,122.38
1.1.6 НӨӨЦИЙН БАРАА	9а	86,700	154,820.04
1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		23,820,704.72	26,969,312.64
1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	23,820,704.72	26,969,312.64
1.2.2.01 Газар		0.0	4,497
1.2.2.02 Биет хөрөнгө		23,493,593.77	26,506,245.34
1.2.2.03 Биет бус хөрөнгө	13	327,110.95	458,570.3
<b>1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2</b>		<b>28,532,250.45</b>	<b>36,326,981.77</b>
2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР		1,166,265.68	2,896,713.81
2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		1,166,265.68	2,896,713.81
2.1.1.03 Өглөг		1,087,012.74	2,866,391.06
2.1.1.04 Урьдчилж орсон орлого	18а, 18б	79,252.94	30,322.75
2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		27,365,984.77	33,430,267.95
2.2.1 Засгийн газрын хувь оролцоо		27,365,984.77	33,430,267.95
2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал		715,438.06	715,438.06
2.2.1.02 Өмч /төрийн/ /ТӨҮГ/		4,809,936.44	4,809,936.44
2.2.1.07 Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/		0.0	4,497
2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн		20,641,279.95	26,701,066.14
2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		1,199,330.32	1,199,330.32
<b>2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5</b>		<b>28,532,250.45</b>	<b>36,326,981.77</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		45,941,483.62	23,122,870.71
1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО		1,719,352.31	1,552,788.31
1.1.1.03.1 Орлогын албан татвар		1,418,743.53	908,311.51
1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар		1,418,743.53	908,311.51
1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар		157,778.7	84,515.76
1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж		142,830.08	559,961.03
1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	12,090,407.38	21,570,082.41
1.1.1.04.3 Тусламжийн орлого		0.0	8,950,440.54
1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		32,131,723.93	0.0
1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	30,531,440.88	7,759,878.59
1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ		30,531,440.88	7,759,878.59
1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		16,991,671.66	7,660,193.09
1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,575,513.76	1,911,396.97
1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		190,818.91	233,508.84
1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		243,464.28	835,903.28
1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал		10,233,555.38	240,331.62
1.1.2.01.1.05 Нормативт зардал		4,297	1,096
1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал		578,096.1	656,151.06
1.1.2.01.1.07 Томилот, зочны зардал		4,914.7	4,659.3
1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		1,694,756.69	555,220.72
1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал		2,466,254.85	3,221,925.3
1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		13,539,769.21	99,685.5
1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		15,410,042.74	15,362,992.12
1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		4,261,177.13	8,801,305.57
1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)		-4,261,177.13	-8,801,305.57
<b>1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)</b>		<b>11,148,865.61</b>	<b>6,561,686.55</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлангийн үзүүлэлт	/мянган төгрөгөөр/	
	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	35,114,807.18	21,030,461.97
1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	1,482,352.99	1,552,788.31
1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	1,181,169.21	908,311.51
1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	157,778.7	84,515.76
1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	143,405.08	559,961.03
1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	24,902.15	5,863.66
1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	116,273.01	550,761.29
1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	2,229.92	3,336.08
1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,486,380.64	19,477,673.66
1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	1,486,380.64	5,191,223.51
1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	8,983,414.45
1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	5,303,035.7
1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	32,146,073.56	0.0
1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	19,518,644.71	6,153,628.72
1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	19,518,644.71	6,153,628.72
1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,978,110.99	6,053,943.22
1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,931,397.79	2,320,054.61
1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	303,191.67	317,088.27
1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	866,457.78	923,492.69
1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	385,246.93	827,096.24
1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	25,900	6,836.75
1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	675,053.8	755,370.56
1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	4,914.7	4,659.3
1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,623,420.45	802,527.29
1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	162,527.88	96,817.51
1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	13,540,533.72	99,685.5
1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	15,596,162.47	14,876,833.25
1.1.2.1 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	178.22	0.0
1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	13,499,535.83	8,583,845.43
1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	13,499,535.83	8,583,845.43
1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	13,499,535.83	8,583,845.43
1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-13,499,357.62	-8,583,845.43
1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	100,738.2	100,000

1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-100,738.2	-100,000
1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	1,996,066.66	6,192,987.82
1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,560,324.14	3,556,390.8
1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,556,390.8	9,749,378.62

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,525,374.5	1,199,330.3	7,530,534.5	14,255,239.3
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	1,961,879.8	1,961,879.8
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,525,374.5	1,199,330.3	9,492,414.3	16,217,119.2
Тайлант үеийн үр дүн	-	-	11,148,865.6	11,148,865.6
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,525,374.5	1,199,330.3	20,641,280.0	27,365,984.8
2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	5,525,374.5	1,199,330.3	20,641,280.0	27,365,984.8
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	4,497.0	-	(501,900.4)	(497,403.4)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,529,871.5	1,199,330.3	20,139,379.6	26,868,581.4
Тайлант үеийн үр дүн	-	-	6,561,686.5	6,561,686.5
2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	5,529,871.5	1,199,330.3	26,701,066.1	33,430,268.0

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Татаас, санхүүжилтийн орлого	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Зөрүү %
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	15,653,705.20	13,563,755.49	2,089,949.71	13.35
Татварын бус орлого	15,653,705.20	13,563,755.49	2,089,949.71	13.35
Тусламжийн орлого	10,178,730.60	6,751,715.90	3,427,014.70	33.67
Төсвөөс санхүүжих	10,178,730.60	6,751,715.90	3,427,014.70	33.67
Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	5,418,595.50	5,303,035.70	115,559.80	2.13
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	5,418,595.50	5,303,035.70	115,559.80	2.13
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	19,208,215.50	13,246,828.30	5,961,387.20	31.04
НИЙТ ЗАРЛАГА	19,080,409.10	13,146,828.30	5,933,580.80	31.10
УРСГАЛ ЗАРДАЛ	5,246,493.20	4,598,512.78	647,980.42	12.35
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,143,748.10	4,500,463.48	643,284.62	12.51
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,179,549.80	1,867,786.34	311,763.46	14.30
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	272,944.10	229,653.82	43,290.28	15.86
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	905,167.90	841,042.00	64,125.90	7.08
Хангамж, бараа материалын зардал	180,752.10	153,442.22	27,309.88	15.11
Нормативт зардал	10,000.00	6,836.75	3,163.25	31.63
Эд хогшил, урсгал засварын зардал	805,219.60	763,710.56	41,509.04	5.15
Томилолт, зочны зардал	11,500.00	4,659.30	6,840.70	59.48
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	666,505.70	546,515.00	119,990.70	18.00
Бараа үйлчилгээний бусад зардал	112,108.90	86,817.51	25,291.40	22.56
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	102,745.10	98,049.30	4,695.80	4.57
Бусад урсгал шилжүүлэг	102,745.10	98,049.30	4,695.80	4.57
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	13,833,915.90	8,548,315.52	5,285,600.38	38.21
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	127,806.40	100,000.00	27,806.40	21.76
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(3,554,510.30)	316,927.18	(3,871,437.48)	108.92
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(3,554,510.30)	(316,927.18)	(3,237,583.12)	91.08
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(3,554,510.30)	(316,927.18)	(3,237,583.12)	91.08
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	(3,554,510.30)	1,587,521.34	(5,142,031.64)	144.66

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
1	1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	376,737.55
12	1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	376,737.55
122	1.1.1.1.1.1 Тусламжийн орлого	376,737.55
1221	1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/	376,737.55
12213	1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого	376,737.55
350013	1.1.1.1.1.1.1.1.3 ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	376,737.55
II	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	343,763.64
21	1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	343,763.64
210	1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	342,127.44
2101	1.1.1.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	27,642.72
2102	1.1.1.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,855.03
2104	1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	87,064.40
2106	1.1.1.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	6,660.00
2108	1.1.1.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	206,905.29
2109	1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	10,000.00
213	1.1.1.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,636.20
4	1.1.1 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	32,973.91
5	1.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(32,973.91)
6	1 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(32,973.91)

## ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

### 3.1 Төсвийн шууд болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн тайлангийн аудит

Жаргалант сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 5 байгууллага тайлангаа нэгтгүүлсэн ба үүнээс 2 байгууллагыг түүвэрт хамруулж, 3 байгууллагад санал дүгнэлт гаргажээ.

Боловсрол, соёл, эрүүл мэндийн байгууллагууд нь босоо тогтолцоотой тул орон нутгаас авсан санхүүжилтийн хүрээнд орлого, зардлаа тайлагнаж байна.

Хүснэгт №9. Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

№	Байгууллагын ангилал	Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр (тоогоор)				Нийт дүн
		ТАБ		ХАК		
		Дүгнэлт	Түүвэр	Дүгнэлт	Түүвэр	
1	Төсөвт байгууллага	2	-	-	-	2
2	ОНӨХК	1	-	-	-	1
3	Төсөл сан	-	2	-	-	2
	<b>Дүн</b>	<b>3</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>5</b>

Дүгнэлт гаргасан 3 байгууллагын 2-т нь өөрчлөлтгүй санал дүгнэлт, 1 байгууллагад хязгаарлалттай дүгнэлт өгсөн байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 196.9 сая төгрөгийн 29 зөрчил<sup>1</sup> илэрснээс, 11.8 сая төгрөгийн 10 төлбөрийн акт тогтоож, 173.8 сая төгрөгийн 5 албан шаардлага хүргүүлж, 11.3 сая төгрөгийн 14 зөвлөмж өгсөн байна.

Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн зөрчил, тэдгээрийн шийдвэрлэлтийг энэ тайлангийн 7-д харуулав.

### 3.2 Жаргалант сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит

Аудитын явцад залруулга хийгдээгүй болно.

Аудитаар нийт 530.7 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрч 5 зөвлөмж өгсөн.

#### 3.2.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй.

#### 3.2.2 Албан шаардлага

Албан шаардлага хүргүүлээгүй болно.

#### 3.2.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## **1. Татварын орлоготой холбоотой асуудал**

### Илрүүлэлт:

Сумын татварын орлогын төлөвлөгөө 6.9 хувиар давж биелсэн ч үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар, хөрөнгө борлуулсны орлого зэрэг 8 орлогын төлөвлөгөө 105.5 сая төгрөгөөр тасарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41.2-т "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ", 41.2.1-т "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасантай нийцэхгүй, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Өгсөн зөвлөмж:

Сумын татварын орлогыг бүрдүүлэх талаар Татварын газартай хамтран ажиллаж, ажлын уялдааг сайжруулах.

## **2. Орон нутгийн нэмэгдэлтэй холбоотой асуудал**

### Илрүүлэлт:

Орон нутгийн нэмэгдлийг Төрийн захиргааны албан хаагчдад 20 хувиар илүү тогтоож 50.1 сая төгрөг, "Жаргалант ус дулаан түгээх станц" ОНӨХК-ын албан хаагчдад 109.7 сая төгрөг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2-д "батлагдсан төсөв хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан "Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох журам"-ын 2.1-д "Орон нутагт ажилласны нэмэгдлийг хөдөөгийн сум (тосгон)-д ажиллаж байгаа төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид тухайн эрхэлж байгаа албан тушаалын үндсэн цалингийн 40 хувиар, аймгийн төв болон нийслэлийн алслагдсан Багануур, Багахангай, Налайх дүүрэгт ажиллаж байгаа төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид тухайн эрхэлж байгаа албан тушаалын үндсэн цалингийн 20 хувиар тус тус бодож, сар бүр олгоно", аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн "Аймгийн 2025 оны төсөв батлах тухай" 03/13 тогтоолтой нийцэхгүй байна.

### Өгсөн зөвлөмж:

Орон нутгийн нэмэгдлийг зориулалтын дагуу зарцуулахад хяналт тавьж, үлдэгдлийг төвлөрүүлэх.

## **3. Дотоод хяналтын үйл ажиллагаатай холбоотой асуудал**

### Илрүүлэлт:

Жаргалант сумын Засаг даргын эрхлэх хүрээний харьяа 5 байгууллагын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 11.8 сая төгрөгийн зөрчилд 10 төлбөрийн акт тогтоож, 173.8 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага хүргүүлж, 11.3 сая төгрөгийн зөрчилд 14 зөвлөмж өгсөн байна. Тамгын газрын санхүү төрийн сангийн хэлтсийн хяналт үр

нөлөөгүйгээс орон нутгийн нэмэгдлийг үндсэн үйл ажиллагааны зардалд гүйлгэн зарцуулсан, анхан шатны нотлох баримт хангалтгүй зэрэг зөрчил илэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 15.4-т "Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 15.4.1-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Харьяа байгууллагуудын батлагдсан төсөв, зарцуулалтад хяналтыг хэрэгжүүлж, дотоод хяналтыг сайжруулах Орон нутгийн хөгжлийн сантай холбоотой асуудал

**4. Дотоод хяналтын үйл ажиллагаатай холбоотой асуудал**

Илрүүлэлт:

Сумын орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр хэрэгжсэн 40 ТАХ-ний хугацаа дууссан ч, барьцаа 68.6 сая төгрөгийг 2026 оны шилжих үлдэгдлээр төсөвт батлуулж, өр төлбөрийг бууруулах арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4-д "үнэн зөв байх", Төсвийн тухай хуулийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 7.7-д "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Байгууллага, иргэн тус бүрээр барьцаа хөрөнгийн дансны үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, эзэн холбогдогчгүй барьцаа хөрөнгийг Орон нутгийн орлогод төвлөрүүлэх.

**5. Шилэн данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Тайлант хугацаанд ТТЗ-ийн мэдээлбэл зохих 169 мэдээллээс 6 мэдээллийн хугацааг хоцроож тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх"; 16.5.7-д "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах"; Шилэн дансны тухай хуулийн 6.1-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ"; 7.1-т "Шилэн дансны мэдээллийг энэ хуулийн дагуу иргэн олон нийтэд хүргэх үүргийг дараах албан тушаалтан хүлээнэ", 7.1.3-т "тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтан" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэх мэдээллийг хуулийн хугацаанд үнэн зөв, бодитой, иж бүрэн мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Сумын татварын орлогын төлөвлөгөө 6.9 хувиар давж биелсэн ч үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар, хөрөнгө борлуулсны орлого зэрэг 8 орлогын төлөвлөгөө 105.5 сая төгрөгөөр тасарсан байна.	1	105.5					1	105.5				
Орон нутгийн нэмэгдлийг Төрийн захиргааны албан хаагчдад 20 хувиар илүү тогтоож 50.1 сая төгрөг, “Жаргалант ус дулаан түгээх станц” ОНӨХК-ын албан хаагчдад 109.7 сая төгрөг олгосон	1	159.8					1	159.8				
Жаргалант сумын Засаг даргын эрхлэх хүрээний харьяа 5 байгууллагын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 11.8 сая төгрөгийн зөрчилд 10 төлбөрийн акт тогтоож, 173.8 сая төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага хүргүүлж, 11.3 сая төгрөгийн зөрчилд 14 зөвлөмж өгсөн байна. Тамгын газрын санхүү төрийн сангийн хэлтсийн хяналт үр нөлөөгүйгээс орон нутгийн нэмэгдлийг үндсэн үйл ажиллагааны зардалд гүйлгэн зарцуулсан, анхан шатны нотлох баримт хангалтгүй зэрэг зөрчил илэрсэн	1	196.9					1	196.9				
Сумын орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр хэрэгжсэн 40 ТАХ-ний хугацаа дууссан ч, барьцаа 68.6 сая төгрөгийг 2026 оны шилжих үлдэгдлээр төсөвт батлуулж, өр төлбөрийг бууруулах арга хэмжээ авч ажиллаагүй	1	68.6					1	68.6				
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>530.7</b>					<b>4</b>	<b>530.7</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тайлант хугацаанд ТТЗ-ийн мэдээлбэл зохих 169 мэдээллээс 6 мэдээллийн хугацааг хоцроож тайлагнасан	1	-	-	-	-	-	1	-
Дүн	1	-	-	-	-	-	1	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн		-	-	-	-	-	-	-
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>

**АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ**

**Нэгтгэлд хамрагдсан нийт байгууллагуудын аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр

№	Байгууллагын нэр	Дүгнэлт гаргах	Түүвэрт	Гаргасан дүгнэлт				Алдаа зөрчлийн ангилал						Аудитаар илэрсэн нийт алдаа, зөрчлийн дүн	
				Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Таггалзсан	Аудитаар өгсөн зөвлөмж		Аудитын явцад өгсөн албан шаардлага		Аудитын явцад тогтоосон төлбөрийн акт			
								Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Орхон аймгийн Жаргалант сумын Засаг дарга	1		1				5	530.7					5	530.7
2	Жаргалант сумын ЗДТГ	1		1				6	5.6	2	55.1	3	6.8	11	67.6
3	Жаргалант сумын ИТХурал	1		1				3	3.9			2	2.2	5	6.1
4	Жаргалант сумын ОНХСан		1					1	1.8	1	2.8	1	0.0	3	4.6
5	Жаргалант сумын Хоршоо хөгжүүлэх сан		1					2	0.0					2	0.0
6	Жаргалант ус, дулаан түгээх станц ОНӨХК	1			1			2	0.0	2	115.9	4	2.8	8	118.6
<b>Бүгд дүн</b>		<b>4</b>	<b>2</b>	<b>4</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>19</b>	<b>542</b>	<b>5</b>	<b>173.8</b>	<b>10</b>	<b>11.8</b>	<b>34</b>	<b>727.6</b>

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ	1	1			1			
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			